

**БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
8 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2021.08.25

Баруун-Урт

НЭГ.ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

8 дугаар сард тус Тамгын газраас явсан болон Тамгын газарт ирсэн бичиг

Явсан бичиг 14

Ирсэн бичиг 22

- Хариутай бичиг 9
- Хугацаандаа явсан 6
- Хугацаа болоогүй 3

Тус Тамгын газраас явсан бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлж ажилласан. Мөн ирсэн албан бичгийг удирдлагад цаг тухай бүрд танилцуулан холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгч ажиллалаа. Тайлант сарын байдлаар Засаг даргын “А” захирамж- 16 , Тамгын газрын даргын “Б” тушаал-8 тус тус гарсан байна.

5 иргэнд архивын лавлагаа өгсөн байна.

ТУС СУМЫН ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВИЙН АЖЛЫН ТАЛААР:

Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй мэдээллэх ажлын хүрээнд мал угаалга , малын татвар, вакцинжуулалтын баннер бэлтгэх, цахим хуудсанд байрлуулж ажилласан. Мөн цаг үеийн 11 мэдээг Baruun-urt.su.gov.mn сайтад, 11мэдээ , 2 судалгаа Баруун-Урт сумын ЗДТГ-ын пэйж хуудсанд байршуулж иргэдийг мэдээ мэдээллээр ханган ажилласан. BBS Телевизтэй хамтран 3 мэдээ, 1 нэвтрүүлэг 1 шторк бэлтгэн иргэдэд хүргэж ажилласан.

Сумын Засаг дарга албан болон хувийн ажлаар 29 иргэнийг хүлээн авч уулзан тэдний тулгамдаж буй асуудал, санал хүсэлтийг сонсож ажилласан байна. 2021 оны эхний хагас жилийн өргөдөл гомдлын мэдээ тайлан гаргасан. Эхний хагас жилд Нийт-1582 өргөдөл гомдол ирсэнээс шийдвэрлэсэн-1517, шилжүүлсэн-30, хугацаа болоогүй-35 байсан.

Цаг үеийн судалгаанд хугацаанд холбогдох газруудад хүргүүлсэн

- Хувиараа хөдөлмөр эрхлэгчинсудалгаап
- Малчин өрхийн судалгаа
- Ажилгүй иргэдийн судалгаа
- Ажилтай иргэдийн судалгаа
- Оюутны судалгаа

- ХЭБ-ийн үйлчилгээ авдаг өрхийн судалгааг ХХҮГ-т хүргүүлсэн.

Боловсрол соёл урлагийн газарт 2021-2022 оны хичээлийн шинэ жилд элсэн орох 6 настай 647 хүүхдийн нэрчилсэн судалгааг гаргаж өгсөн.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ,

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Шарилж устгалын ажлын чиглэлээр Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран нийтийг хамарсан ажилд 10 иргэнийг түр ажлын байраар хангаж 10 өдрийн хугацаанд 13000 мк талбайг цэвэрлэсэн байна.
- Багийн нутаг дэвсгэрт шарилж устгалын ажлыг зохион байгуулж нийтийн эзэмшлийн зам талбайд ХЭБ авдаг өрхүүдийг дайчлан ажлуулсан.
- Ногоон байгууламжийг хариуцан гүйцэтгэх ОНӨААТҮГ-ыг шинээр байгуулж Сумын ИТХ-ын тогтоолыг гаргуулсан.
- Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр Японы ядуурлыг бууруулах сангийн төслөөр нэгдсэн хогийн цэгт тохижилтын ажил хийгдэж байна
- БОХ-6.1, БОХ-6.2 энгийн хог хаягдлын тайлан, аюултай хог хаягдлын тайланг хагас жилээр гаргаж байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлсэн.
- Нүхэн жорлонг ариутгагч Тамир био бэлдмэлийг 9 багийн 300 өрхөд хүлээлгэн өгч ариутгалын ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Аймгийн Засаг даргын 2021 оны А/297 дугаар захирамжаар боловсон жорлон хийх төслийг хэрэгжүүлж нийт 10 өрхөд байршуулсан.
- Ногоон байгууламжийг хашиж хамгаалах ажлыг 2000 мкв талбайд хийсэн.
- Хур тунадас их хэмжээгээр орж төвийн нийтийн эзэмшлийн орон сууцны орц, төрийн байгууллагын эзэмшлийн талбайд хуримтлагдсан усыг зөөвөрлөсөн.
- 7 дугаар багийн 27 б байрны дээврийн засварын ажил хийгдэж байна.
- Багуудын гэр хорооллын цамхагт гэрэлтүүлэг байршуулах ажлыг Уртын гэгээ ОНӨААТҮГгүйцэтгэж байна.

ГУРАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хөдөө аж ахуй бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн ХАА-3 мэдээг 4-н аж ахуй нэгжээс, газар тариалангийн бүтээгдэхүүний үнийн ХАА-10 мэдээг 1 иргэнээс авч нэгтгэн статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.

Хонь, тэмээний ноосны урамшуулалд хамрагдах тус сумын 9-н багийн малчин болон мал бүхий 547 өрхийн урамшууллын падааны мэдээллийг шивж хөдөө аж ахуй газарт хугацаанд нь хүргүүлсэн болно.

Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн 14 бяруун бухыг малчдад түрээсийн гэрээгээр олгож малын чанарыг сайжруулах бодлого барин ажиллаж байна.

Сумын хэмжээнд худалдаа үйлчилгээний 25 кароеке баар, 77 дэлгүүртэй нийт 107 аж нэгж байгууллагуудтай Хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна.

ДӨРӨВ. МАЛ ЭМНЭЛГИЙН ТАСАГ

Сэлэнгэ үүлдрийн 14 бяруун бухад үзлэг хийж, бруцёллзын шинжилгээнд бүрэн хамруулж, шимэгдэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор туулгадаж, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан.

Сүхбаатар аймгийн Засаг даргын А/119 тоот захирамжийн дагуу малын шоц халдварт паразит дах өвчнөөс урьдчилан сэргийлэх мал угаалгын ажилд үхэр 542, хонь 104429, ямаа 52795, тус бүр хамрагдаад байна.

ТАВ.САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Сум хөгжүүлэх сан

Сум хөгжүүлэх сангийн хүрээнд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж зээлийн хүү болон үндсэн зээлийн төлөлтөд тогтмол хяналт тавьж, зээл төлөлтийг хуваарийн дагуу тухай бүрт төлүүлж байна.

Сум дундын иргэний анхан шатны шүүхэд дэх эвлэрлийн жуулчлалт шилжүүлсэн нэхэмжлэлийн дагуу 6 иргэний 4,8 сая төгрөг хугацаа хэтэрсэн 2 иргэний 4,3 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сан

Орон нутаг хөгжүүлэх сангийн удирдлага мэдээллийн сангийн хуваарлалт төлөвлөлт хэрэгжилт цэсэнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээний мэдээллийг тухай бүр оруулж танилцуулсан Тус сангаас хийгдэж буй бүтээн байгуулалт сумын Засаг даргын А/175 дугаар захирамжаар байгуулж удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг хийж орон нутгийн ВВС ТЕЛЕВИЗТЭЙ хамтран ажилласан.

Төрийн сан

8 дугаар сарын байдлаар орон нутгийн болон харьяа төсөвт байгууллагуудын 10 285 905 мянган төгрөгний /4692/ мөнгөн зарлагын гүйлгээнд хяналт тавин баталгаажуулсан.

Төрийн сангийн хувьд 1 101 244 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлого орж, татварын орлогын төлөвлөгөө 113 хувьтай биелсэн.

Бусад

7051-3511 аймгийн шуурхай штабын жижүүрээр 6 албан хаагч 24 цагаар жижүүрээр ажилласан.

ЗУРГАА. КОРОНА ВИРУСЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Тусгаарлах 3 байрыг бэлэн байлгаж эмч ажилчдад 5 удаа 1 удаагийн иж бүрэн хамгаалах хувцасаар хангасан. Татан авалтанд 29 байгууллагын жолооч машиныг татан ажилуулж тайлант хугацаанд 83 хүн тусгаарлах байранд тусгаарлагдаж, 78 хүн эдгэрч эмнэлгээс гарсан.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН

/Б.БОЛОРТУУЛ/